ХЯНАН ЗАСВАРЛААГҮЙ ХУВЬ /ТӨСӨЛ/

Distr.: Ерөнхий
2019 оны 08 дугаар
сарын 29
Эх хувь: Англи хэл дээр

Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах хороо

Монгол Улсын 23-24 дүгээр нэгтгэсэн тайланд хийсэн дүгнэлт, зөвлөмж*

1. Монгол Улсын нэгтгэн ирүүлсэн 23-24 дүгээр ээлжит тайланг (CERD/C/MNG/23-24) 2019 оны 08 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд болсон Хорооны 2753, 2754 дэх удаагийн хурлаар (CERD/C/SR. 2753, 2754-г үзнэ үү) авч хэлэлцэв. Энэхүү дүгнэлт, зөвлөмжийг 2019 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар баталсан болно.

A. Оршил

2. Монгол Улсын зүгээс 23-24 дүгээр ээлжит тайланг хугацаандаа ирүүлсэнд талархахын зэрэгцээ хэрэгжилтийн талаарх тайлангуудыг тогтмол хүргүүлдэгийг сайшааж байна. Хорооны зүгээс Монгол Улсыг төлөөлөн ирсэн бүрэлдэхүүнтэй нээлттэй харилцан яриа өрнүүлж, тус яриа хэлэлцээний үеэр Хорооны гишүүдийн зүгээс асуусан асуулт, дэвшүүлсэн асуудлуудад хариулт өгч хүчин чармайлт гаргасныг цохон тэмдэглэж байна.

B. Эерэг алхам

3. Хорооны зүгээс Оролцогч Улс Хүүхдийн эрхийн конвенцийн нэмэлт протоколыг 2015 онд соёрхон баталсныг сайшааж байна.

4. Оролцогч Улс дараах хууль тогтоомжийг баталж, бодлогын хэмжээний арга хэмжээ авсанд талархаж байна:

(a) Ялгаварлан гадуурхах, алагчлах явдлыг хориглосон заалт бүхий Төрийн албаны тухай хуулийг 2017 онд баталсан;

(b) Арьсны өнгө, үндэс, угсаагаар ялгаварласан үйлдлийг эрүүгийн хэрэгт тооцсон зохицуулалт агуулсан Эрүүгийн хуулийг 2015 онд, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баталсан;

(c) Цагаач ажилчдыг хамгаалахтай холбоотой заалтууд агуулсан Хөдөлмөрийн тухай хуулийг 2015 онд баталсан.

C. Анхаарах зүйлс, зөвлөмжүүд

Мэдээлэл цуглуулах

5. Оролцогч Улсын зүгээс 2015 оны Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн дагуу хийгдсэн тооллогын дүнд гаргасан Казак, Тува, Цаатан (Духа) иргэдийг насны ангилал, ажил эрхлэлт, боловсролын талаар мэдээлэл ирүүлснийг талархан тэмдэглэж байгаа боловч арьс үндсээр алагчлах байдал байж болзошгүй, тусгай арга хэмжээ авах шаардлагатай угсаатны бүх бүлгүүд, тухайлбал үндэстний цөөнх, уугуул иргэд, орогнол хүсэгч, дүрвэгсэд болон харьяалалгүй хүмүүсийн талаарх нийгэм, эдийн засгийн цогц, хамгийн сүүлийн байдлаар гаргасан, найдвартай мэдээлэл дутмаг байгаад харамсаж байна. (2 дугаар зүйл).

* Хорооны 99 дүгээр чуулганаар (2019 оны 08 дугаар сарын 05-29-ний өдрүүд).

6. Тайлан боловсруулах тухай удирдамж (CERD/C/2007/1, 10, 12 дугаар хэсэг)-д заасныг харгалзан Оролцогч Улс болон Хорооны хувьд ялгаварлан гадуурхах явдал бодитой оршиж байгаа эсэхийг тодорхойлох, тодорхой хугацаанд авсан арга хэмжээний үр нөлөө, үр дүнг тодорхойлохын тулд нарийвчлан задалсан статистик мэдээлэл цуглуулах аргачлалыг бий болгон батлахыг Оролцогч Улсад Хорооны зүгээс зөвлөж байна. Оролцогч Улс нь цалин хөлс, ядуурал, дундаж наслалттай холбоотой нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүдийн талаарх мэдээлллийг, мөн хувь хүмүүс, нийгмийн бүлэг өөрийгөө тодорхойлж байгаад үндэслэн үндэстэн, бүх угсаатны бүлэг, уугуул иргэд, цагаач, харьяалалгүй хүмүүсийн эрүүл мэндэд нөлөөлж буй байгаль орчны нөлөөллийн талаарх үзүүлэлт бүхий мэдээллийг дараагийн ээлжит тайланд оруулахыг Хорооны зүгээс хүсч байна.

Ялгаварлан гадуурхалтын эсрэг хууль тогтоомж

7. Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судлагааны дүнд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 34 хууль ялгаварлан гадуурхахыг хориглосон зохицуулалттай байгаа талаарх мэдээлэл Оролцогч Улсаас өгснийг Хороо тухайлан тэмдэглэж байна. Хэдий тийм боловч Конвенцийн 1 дүгээр зүйлд заасны дагуу алагчлах үзэл, ялгаварлан гадуурхах тухай тодорхойлолт агуулсан тодорхой хууль тогтоомж байхгүй байна гэсэн зөвлөмжийг дахин санууулж байна (1 дүгээр зүйл).

8. Хорооны зүгээс өмнө өгч байсан (CERD/C/MNG/CO/19-22) Конвенцийн 1 дүгээр зүйлд заасны дагуу алагчлах үзэл, ялгаварлан гадуурхахыг тодорхойлсон мөн арьс үндсээр алагчилах бүх хэлбэрийг хориглосон тодорхой хууль тогтоомжийг батлах тухай зөвлөмжийг Оролцогч Улсад дахин санууулж байна.

Үндэсний хэмжээний хүний эрхийн байгууллага

9. Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан Комиссарын албан тушаалд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангах, өөрийн бие даасан байдлыг хадгалах талаарх зохицуулалтыг тусгаж байгааг Хорооны зүгээс сайшааж байна. Хүний эрхийн Комиссын үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад хангалттай санхүүжилт, хүний нөөц байхгүй байгаад Хорооны зүгээс анхаарал хандуулж байна (2 дугаар зүйл).

10. Хорооны зүгээс Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Парисын зарчимд бүрэн нийцсэн бөгөөд хараат бус Хүний эрхийн үндэсний комиссыг бий болгож байгаа эсэхийг нягтлахыг Оролцогч Улсад зөвлөж байна. Парисын зарчимд бүрэн нийцсэн бие даасан байдалтай өөрийн мандатыг үр дүнтэй хэрэгжүүлдэг комисстой болохын тулд Хүний Эрхийн Үндэсний Комисст боломжит хүний нөөц болон санхүүгийн эх үүсвэрийг олгох, хуваарилахыг Оролцогч Улсад Хорооны зүгээс зөвлөж байна.

Арьс үндсээр алагчилах, үзэн ядсан үг хэллэг

11. Үзэн ядах үг хэллэгийг хориглох зохицуулалтыг Конвенцийн 4 дүгээр зүйлд нийцүүлэн одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хүртэл агуулагдаагүй байгааг Хороо авч үзэж байна. Үзэн ядсан үг хэллэг хэрэглэх нь үндэсний эв нэгдлийг сарниулахад хүргэж болзошгүй хэсгийг гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд оруулсан байгааг Хорооны зүгээс онцолж байна. Түүнчлэн олон нийтийн сүлжээгээр арьс үндсээр ялгаварлах, алагчилахтай холбогдуулан үзэн ядсан үг хэллэгийг ихээр хэрэглэх болсон тодруулбал 2017 онд болсон Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр олон нийтийн сүлжээгээр ийм төрлийн үг хэллэг хэрэглэсэн, мөн үндсэрхэг үзлийг дэвэргэн үзэн ядах үг хэллэг хэрэглэсний дүнд хохирсон хохирогчдоос гомдол гаргасан эсэх талаар, дээрх үйлдлийг хийсэн буруутнуудыг мөрдөн шалгасан, ялласан эсэх талаар мэдээлэл дутмаг байгааг Хороо анхаарлаа хандуулж байна. (4 дүгээр зүйл).

12. Хорооны зүгээс өмнө өгч байсан (CERD/C/MNG/CO/19-22) зөвлөмжийг дахин санууулан Конвенцийн 4 дүгээр зүйлд нийцүүлэн арьс үндсээр алагчилж үзэн ядах үг хэллэгийг хориглон дараах байдлаар гэмт хэрэгт тооцох, тухайлбал: “(a)

хэт үндсэрхэг үзэл, илт үзэн ядсан байдалд тулгуурлан илэрхийлсэн үзэл санааг бүх байдлаар түгээх; (b) арьс үндсээр алагчилах, ялгаварлан гадуурхахыг өдөөн турхирах; (c) өөр арьсны өнгө, угсаатны гарал бүхий хүмүүсийн бүлэг эсхүл аливаа төрлийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн, өдөөн турхирсан зэрэг арьс үндсээр алагчилж үзэн ядах үг хэллэгийг шууд хориглосон зохицуулалтыг одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бий болгохыг Оролцогч Улсад зөвлөж байна. Эрүүгийн хуульд заасан үндэсний эв нэгдлийг сарниулах гэмт хэргийн заалтыг Конвенцоор хамгаалагдсан үндэстний цөөнх, бусад угсаатны бүлгийн гишүүдийг тэдгээрийн Конвенцоор баталгаажсан эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх эсхүл тэдгээрийн манлайлагч, тэдгээрийн бодлого, тэдгээрийн үйлдлийг шүүмжилсэн аливаа шүүмжлэлд ял шийтгэл ногдуулж, хариуцлага тооцох арга зам гэсэн утгаар тайлбарлаж, хэрэгжүүлэхгүй байгааг Оролцогч Улс нягталж үзэхийг Хорооноос зөвлөж байна.

Арьс үндсээр алагчилахыг дэмжигч байгууллага

13. Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөлд хуулийн этгээдийг арьс үндсээр алагчилсан, ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаа явуулахыг хориглох, улмаар татан буулгахтай холбоотой зохицуулалт тусгагдаж байгаа тухай Оролцогч Улсын өгсөн мэдээллийг Хороо онцолж байна. Гадаад хүмүүсийн эсрэг үзэн ядсан үг хэллэг хэрэглэхийг дэмжиж, олон нийтийн дунд ийм үг хэллэг хэрэглэж байгаа хэд хэдэн бүлэг, хэт үндсэрхэг үзэлтэй байгууллагууд бодитой оршин байгааг Хороо анхааралдаа авч байна. Даяар Монгол зэрэг ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг бүртгэлтэй байгууллагууд татан буугдсан талаар Оролцогч Улсын зүгээс өгсөн тайлбарыг тэмдэглэхийн зэрэгцээ ийм төрлийн хуулийн этгээдийг эрэн сурвалжлах, мөрдөх, яллах, хариуцлага тооцож буй талаар мэдээлэл байхгүй байгааг Хорооны зүгээс анхаарлаа хандуулж байна (4 болон 7 дугаар зүйл).

14. Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төсөлд тусгагдаж байгаа хуулийн этгээдийг арьс үндсээр алагчилсан, ялгаварлан гадуурхсан үйл ажиллагаа явуулахыг хориглох, улмаар татан буулгахтай холбоотой зохицуулалт Конвенцийн 4 дүгээр зүйлтэй нийцэж байгаа эсэхийг Оролцогч Улс нягтлахыг Хорооны зүгээс зөвлөж байна. Өөрийн хууль тогтоомжийг тэр дундаа хуулийн дагуу бүртгэлтэй бүх байгууллага арьс үндсээр ялгаварлахыг эсхүл хэт үндсэрхэг үзлийг дэмжвэл хориглож, хууль бус гэдгийг зарлах замаар хууль тогтоомжоо үр дүнтэй хэрэглэхийг Оролцогч Улсад Хорооны зүгээс зөвлөж байна.

Орогнол хүсэгч, дүрвэгсэд болон харьяалалгүй хүмүүс

15. Монгол Улсад оршин сууж байгаа гадаадын иргэд монгол иргэдтэй адил эрх эдлэхээр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасныг тэмдэглэхийн зэрэгцээ дүрвэгсдийн талаарх дотоодын хууль тогтоомж байхгүй байх тул орогнол хүсэгч, дүрвэгсэд, харьяалалгүй хүмүүс зэрэг тухайлан бүртгэлд ороогүй хүмүүсийн хувьд эрүүл мэндийн, нийгмийн халамжийн, боловсролын зэрэг төр засгаас үзүүлдэг үйлчилгээ авахад хүндрэл учирч болохыг Хороо анхаарлаа хандуулж байна (2 болон 5 дугаар зүйл).

16. Орогнол хүсэгч, дүрвэгсэд, харьяалалгүй хүмүүс ямар нэг алагчилалгүйгээр эрүүл мэндийн, нийгмийн халамжийн, боловсролын болон ажил эрхлэх боломжоор хангагдах эрхийг бүрэн баталгаажуулах үр дүнтэй арга хэмжээ Оролцогч Улс авахыг Хороо зөвлөж байна. Хорооны зүгээс Оролцогч Улсыг Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай 1951 оны Конвенц, уг Конвенцийн 1967 оны Нэмэлт Протоколыг соёрхон батлахыг уриалж байна.

Цагаач ажилчид

17. Цагаач ажилчдын ажиллах болон амьдрах нөхцөл стандартаас доогуур байгаа, эдгээр хүмүүс монгол ажилчдын нэг адил ажлын байрны ижил нөхцөлөөр хангагдаж байгаа эсэхийг нягталдаг үр дүнтэй хяналт шалгалт, мониторингийн механизм дутагдалтай байгааг Хороо анхаарлаа хандуулж байна (2 болон 5 дугаар зүйл).

18. Оролцогч Улсын зүгээс хүчээр, албадан хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх, цагаач ажилчдыг

хамгаалах тухайлан ямар нэг алагчилалгүйгээр эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой үйлчилгээ авах тэдгээрийн эрхийг бүрэн баталгаажуулах үр дүнтэй арга хэмжээ авахыг Хороо зөвлөж байна. Мөн Оролцогч Улсын зүгээс цагаач ажилчдын ажиллах болон амьдрах нөхцөл стандартаас доогуур байгаатай тэмцэх, эдгээр хүмүүс монгол ажилчдын нэг адил ажлын байрны ижил нөхцөлөөр хангагдаж байгаа эсэхийг нягталдаг үр дүнтэй хяналт шалтгалт, мониторингийн механизмыг бий болгох, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай болон Хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай конвенцууд (№81, №129), Гэрийн үйлчилгээний ажилчдын тухай конвенц (№189), Цагаач ажилчдын тухай конвенц (№143) зэрэгт заасан олон улсын стандартуудтай нийцэж байгаа эсэхийг нягтлахыг Хорооноос зөвлөмж болгож байна.

Үндэстний цөөнх болон уугуул иргэд

19. Үндэстний дундажтай харьцуулахад Казак, Тува, Цаатан (Духа) зэрэг хүмүүсээс цөөн тооны иргэд анхан шатны, ерөнхий болон дээд шатны боловсрол эзэмшиж байгаад Хороо анхаарал хандуулж байна. Хос хэлний боловсролыг дэмжиж буй Оролцогч Улсын хүчин чармайлтыг онцлолж байгаа боловч уугуул иргэд, үндэстний цөөнхийн гишүүд тухайлбал Баян-Өлгий, Хөвсгөл болон Улаанбаатар хотын Налайх дүүрэгт оршин сууж байгаа иргэд хос хэл дээр боловсрол эзэмших боломжоор хангагдахад учирч буй бэрхшээл байгааг, түүнчлэн үндэсний цөөнх, угсаатны бүлгүүд, уугуул иргэд өөрийн эх хэл дээр боловсрол эзэмшихгүй, улмаар үүний дүнд эдгээр бүлгүүдийн хэл мартагдахад хүрч байгааг Хороо анхааралдаа авч байна. Оролцогч Улсын албан ёсны хэл дээр олгож буй боловсролын чанар муу байгаа, үндэсний цөөнх, уугуул иргэд их сургуульд орох шалгалтад муу дүн үзүүлж байгаа, төр захиргааны удирдах албан тушаалуудад ажиллах боломжоор хангагдахгүй, шийдвэр гаргах үйл явцад оролцуулахгүй байгаа зэргээс урьдчилан сэргийлэх асуудалд Хороо анхаарлаа хандуулж байна (5 дугаар зүйл).

20. Оролцогч Улс үндэсний цөөнх, угсаатны бүлгүүд, уугуул иргэд эх хэл дээрээ боловсрол эзэмших боломжоор хангагдах байдлыг сайжруулах, боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлэх, албан ёсны хэлний боловсролын чанарыг дээшлүүлэхэд хангалттай хөрөнгө хуваарилах, тусгай арга хэмжээ авахыг Хороо зөвлөж байна. Оролцогч Улсын зүгээс мөхөж буй долоон хэлийг хамгаалах талаар арга хэмжээ авахыг мөн Хорооноос зөвлөмж болгож байна. Цаатан (Духа) иргэд их, дээд сургуульд суралцахад тодорхой квот бий болгох, тусгайлсан тэтгэлэг санаачлах, бусад угсаатны бүлгүүдэд зориулж энэ төрлийн арга хэмжээг хэрэглэх боломжийг судлахыг хүсч байна.

21. Үндэстний дундажтай харьцуулахад Казак, Тува, Цаатан (Духа) зэрэг хүмүүсийн дунд хөдөлмөр эрхлэлт доогуур байгааг Хороо онцолж байна. Төрийн албаны тухай хуульд угсаа, гарал байдлыг үндэслэн ялгаварлан гадуурхахыг хориглосон зохицуулалт тусгагдсан гэдгийг Хороо сайшаан тэмдэглэж байгаа боловч үндэсний цөөнх хөдөлмөр эрхлэхэд тухайлан Баян-Өлгий аймагт төрийн албанд ороход ялгаварлагдаж байгаа байдал үргэлжилж байгаад Хороо анхаарлаа хандуулж байна (5 дугаар зүйл).

22. Оролцогч Улсын зүгээс үндэс, угсаа гарлаар ялгаварлан ажилд авах, төрийн албанд ажиллуулахад хориг саад тавихгүй байх, хөдөлмөр эрхлэх эрхийг бүх хүнд ижил эдлүүлэх, төрийн албанд ажиллах боломжоор хангах талаарх бүх шаардлагатай арга хэмжээ авахыг Хороо зөвлөж байна.

Цаатан (духа) хүмүүсийн нөхцөл байдал

23. Тэнгис Шишгэдийн тусгай хамгаалалттай газарт ан агнах, загас барихыг хориглосон нь уламжлалт хэв маягаар аж төрөхөд, мөн Цаатан хүмүүсийн соёлын эрхэд сөргөөр нөлөөлж болзошгүйг Хороо анхааралдаа авч байна. Тайлангуудыг судлан авч үзснээр Хорооны зүгээс дараах асуудлуудад анхаарал хандуулж байна. Үүнд:

(a) Уламжлалт байдлаар цаа буга бэлчээхэд ашиглаж байсан бэлчээрийн газарт нэвтрэхтэй холбоотой хориглолт;

(b) Тэдний амьдран суудаг газарт ан агнахыг хориглосон хууль тогтоомжийг шууд хэрэглэхийг анхаарах, амьжиргааны нэг арга болох ан агнахад хорих ял оногдуулж байгааг анхаарах, буруутай этгээдэд хариуцлага тооцох, торгуулийн арга хэмжээ авах;

(c) Цаатан иргэд ОХУ-н Тува Улсын нутаг дэвсгэрт оршин суудаг өөрсдийн садан төрөлтэй уулзахад гардаг бэрхшээл, хил нэвтрэхэд баривчлах, саатуулах зэргээр саад учруулах; мөн

(d) Эрүүл мэндийн үйлчилгээ авахын тулд эмнэлгийн байранд очиход Цаатан иргэдэд тэр дундаа өндөр настай, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тулгарч буй хүндрэл (5 дугаар зүйл).

24. Уугуул иргэдийн эрхийн талаар Ерөнхий зөвлөмж №23 (1997)-н хүрээнд Оролцогч Улсад Хорооноос зүгээс дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

(a) цаатан иргэдийн эрх болон тэдний амьдарч буй газар нутагтай холбоотой аливаа шийдвэр гаргах үйл явцад тэдэнтэй урьдчилж, үр дагаврыг таниулж, мэдүүлсний үндсэн дээр зөвшилцөн үр дүнтэй яриа хэлэлцээ хийж байгаа эсэхийг нягтлах;

(b) цаатан иргэд ахуй соёлоо хадгалах эрхийг бүрэн дүүрэн эдлүүлэх үүднээс ан агнах, загас барих боломжоор хангаж, агнуурын хэмжээг цаатан иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр квот тогтоох;

(c) Тэнгис Шишгэдийн тусгай хамгаалалттай газрын менежментэд цаатан иргэдийг оролцуулж байгаа эсэхийг, мөн цаа буга үржүүлж, бэлчээрлүүлж ирсэн газар нутгаа ашиглах эрх нь хангагдаж байгаа эсэхийг нягтлах;

(d) хилийн чанадад амьдарч буй өөрсдийн төрөл төрөгсөдтэй холбоотой байх, өөрийн угсааны бүлгийн бусад гишүүдтэй харилцаатай байх, харилцаа холбоог хөгжүүлэх, цаашид харилцаагаа хадгалах зэрэг Цаатан иргэдийн эрх хангагдаж байгааг нягтлах;

(e) Цаатан иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр хөдөлгөөнт эрүүл мэндийн клиникээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх боломжийг судлах.

Уул уурхай

25. Цаа бугын бэлчээртэй холбогдуулан эрх ашиг нь хөндөгдөж буй үндэстний цөөнхтэй зөвшилцөхгүйгээр ашигт малтмалын болон хайгуулын зөвшөөрөл үргэлжлүүлэн олгож байгаа нь өөрийн соёлыг хадгалж уламжлалт маягаар аж төрөхөд сөргөөр нөлөөлж байгаа талаарх мэдээллийг Хороо анхааралдаа авч байна. Ийнхүү эрх ашиг нь хөндөгдөж байгаа үндэстний цөөнхийн өв соёлд уул уурхайн үйл ажиллагаа хохирол учруулахгүй байгааг нягтлах зорилгоор нөлөөлийн үнэлгээ хийх төлөвлөгөө байхгүй байгааг Хорооны зүгээс мөн анхаарлаа хандуулж байна (2 болон 5 дугаар зүйл).

26. Цаатан иргэдийн амьдарч, цаа буга үржүүлж байсан газар нутгийг уул уурхайн үйл ажиллагаанд ашиглах зөвшөөрлийг олгохын өмнө цаатан иргэдтэй заавал зөвшилцдөг байх зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тусгахыг Хороо Оролцогч Улсад зөвлөмж болгож байна.

Эрх сэргээлгэх боломж

27. Арьс үндсээр ялгаварлан гадуурхагдсан хохирогчдоос албан ёсоор гомдол гаргаагүй гэдгийг онцлон тэмдэглэж, энэ байдал хуулийн зохицуулалт тодорхой бус байх, эрх сэргээлгэх боломжийн талаар олон нийтийн ойлголт, мэдлэг дутмаг, нийгмийн зүгээс эргээд өөрт нь дарамт учрахаас айх, ийм үйлдлийг төрийн байгууллагын зүгээс мөрдөн шалгах санаачлага гаргахгүй, энэ чиглэлийн асуудалд анхаарал хандуулж ажиллах эрмэлзэлгүй байгааг харуулж байж болох юм гэдгийг Оролцогч Улсад Хорооны зүгээс сануулж байна (6 дугаар зүйл).

28. Конвенцийн Ерөнхий тайлбар №31 (2005)-д ялгаварлан гадуурхахаас

хамгаалсан захиргааны болон эрүүгийн шүүхийн тогтолцоог бүрдүүлэх тухай заасныг онцлоод, энэ хүрээнд бүх нийтийн боловсролыг сайжруулах ялангуяа энэ конвенцид заасан эрх, хөдөлмөрийн салбарт гарч буй зөрчил, ялгаварлан гадуурхалтай холбоотой гомдол гаргах асуудлаар үндэсний цөөнх, уугуул иргэд, цагаач иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах болон зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх шүүхийн механизмыг бүрдүүлэхэд анхаарахыг Хорооноос зөвлөж байна. Оролцогч Улс дээрх асуудлыг тусгасан тусгай сургалтын модулийг "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд бий болгохыг Хорооны зүгээс зөвлөмж болгож байна.

D. Бусад зөвлөмж

Бусад гэрээг соёрхон батлах

29. Хүний эрхүүд бүгд хоорондоо салшгүй холбоотой байдгийг санаж Оролцогч Улс нь арьс үндсээр алагчлах, ялгаварлан гадуурхалтад өртөх боломжтой нийгмийн бүлэгт шууд хамаарах заалтууд бүхий олон улсын гэрээнүүд, тэр дундаа Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас 1989 онд баталсан №169 дүгээр конвенц буюу Цагаач ажилчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүд, уугуул иргэд, овгийн хүмүүсийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцийг хараахан соёрхон батлаагүй байгааг анхаарч соёрхон батлахыг Хорооны зүгээс уриалж байна.

Конвенцийн 8 дугаар зүйлийн нэмэлт өөрчлөлт

30. 1992 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Конвенцид Оролцогч Улсуудын арван дөрөвдүгээр хурлаар баталж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 47/111 тоот тогтоолоор дэмжигдсэн Конвенцийн 8 (6) дугаар зүйлд оруулсан нэмэлт, өөрчлөлт Оролцогч Улс тус нэмэлт өөрчлөлтийг соёрхон батлахыг Хорооноос зөвлөж байна.

Конвенцийн 14 дүгээр зүйлийн дагуух мэдэгдэл

31. Конвенцийн 14 дүгээр зүйлд заасны дагуу хувь хүмүүсээс гаргасан гомдол мэдээллийг хүлээн авч, хэлэлцэх Хорооны эрх хэмжээг хүлээн зөвшөөрч байгааг нэмэлт мэдэгдэл хийх талаар Оролцогч Улс анхаарч үзэхийг Хорооны зүгээс уриалж байна.

Дурбаны Тунхаглал болон үйл ажиллагааны хөтөлбөртэй холбогдуулан авах арга хэмжээ

32. Дурбаны тунхаглалын мөрөөр хийгдсэн чуулга уулзалтаас гаргасан №33(2009) ерөнхий зөвлөмжтэй холбогдуулан Хорооны зүгээс Оролцогч Улсыг өөрийн дотоодын эрх зүйн зохицуулалтын хүрээнд тус Конвенцийг хэрэгжүүлэхдээ Ялгаварлан гадуурхах, арьс үндсээр алагчилах, ксенофоби болон бусад үл тэвчих үзлийн эсрэг Дэлхийн чуулга уулзалтын үеэр буюу 2001 оны 09 дүгээр сард батлагдсан Дурбаны тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ач холбогдол өгч, 2009 оны 04 дүгээр сард Женев хотноо болсон Дурбаны чуулга уулзалтын мөрөөр гаргасан баримт бичгийг анхаарч байхыг Хорооноос зөвлөж байна. Оролцогч Улс дараагийн ээлжит тайландаа Дурбаны тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар үндэсний хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөө, авсан арга хэмжээний талаар тусгахыг Хороо хүсч байна.

Африк гаралтай хүмүүст зориулсан олон улсын арван жил

33. 2015-2024 оныг Африк гаралтай хүмүүсийн олон улсын 10 жил болгон тунхаглаж Ерөнхий Ассамблейгаас 68/237 тоот тогтоол баталсан бөгөөд энэхүү 10 жилийн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийг Ерөнхий Ассамблейн 69/16 тоот тогтоолд тусгасан. Оролцогч Улс дээрх тогтоолтой холбогдуулан бодлого тодорхойлж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх тохирох арга

хэмжээ боловсруулж, хэрэгжүүлэхийг Хорооноос зөвлөж байна. Африк гаралтай хүмүүсийг арьс үндсээр алагчилахгүй байх тухай тус Хорооны баталсан Ерөнхий зөвлөмж №34 (2011)-ийг харгалзан дээрх хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн тодорхой арга хэмжээний талаар нарийвчилсан мэдээллийг дараагийн ээлжит тайланд тусгахыг Хорооны зүгээс хүсч байна.

Иргэний нийгэмтэй зөвлөлдөх

34. Оролцогч Улс нь тус дүгнэлт зөвлөмжийн дагуу арга хэмжээ авах, дараагийн ээлжит тайланг бэлтгэхдээ хүний эрхийг хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг тухайлан арьс үндсээр алагчилахтай тэмцэх чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай яриа хэлэлцээ улам их хийх, зөвлөлдөөнийг цаашид үргэлжлүүлэхийг Хорооноос зөвлөж байна.

Мэдээлэл түгээх

35. Оролцогч Улсын зүгээс өөрийн бэлтгэсэн тайланг хүргүүлсэн тухайн цаг хугацаанаас эхлэн уг тайланг олон нийт олж үзэх болон хандалт хийх боломжтой байдлаар байрлуулах, Хорооноос өгсөн дүгнэлт зөвлөмжүүд болон түүний дагуу бэлтгэсэн тайланг Конвенцийг хэрэгжүүлж байгаа бүх төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд үзэх боломжтой байхаар, түүнчлэн Гадаад харилцааны яамны цахим хуудаст төрийн албан ёсны хэл, мөн боломжтой бол нийтээр хэрэглэдэг бусад хэлээр байршуулахыг Хорооноос зөвлөж байна.

Нийтлэг мэдээлэл бүхий үндсэн баримт бичиг

36. 2006 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан Хүний эрхийн холбогдолтой олон талт гэрээний Хороод хоорондын тав дахь удаагийн хурлаас баталсан (HRI/GEN/2/Rev.6, chap. I) тайлан боловсруулах удирдамжийн дагуу 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Оролцогч Улсаас ирүүлсэн нийтлэг мэдээлэл бүхий үндсэн баримт бичигт агуулагдах мэдээллийг бэлтгэхийг Хорооны зүгээс дэмжиж байна. Түүнчлэн Ерөнхий Ассамблейн 68/268 тоот тогтоолд заасны дагуу уг баримт бичгийг 42,400 хэтрэхгүй үгэнд багтаахыг Оролцогч улс анхаарахыг Хорооны зүгээс анхааруулж байна.

Тус дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ

37. Конвенцийн 9 (1) дүгээр зүйл болон Хорооны үйл ажиллагааны журмын 65 дахь хэсэгт заасны дагуу Хорооноос өгсөн тус дүгнэлт зөвлөмжийн 20, 24 b) болон 24 c) хэсэгт агуулагдах зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Оролцогч Улс нэг жилийн дотор Хороонд хүргүүлэхийг хүсч байна.

Тусгайлан анхаарах хэсгүүд

38. Тус дүгнэлт зөвлөмжийн 6, 8, 12, 14 дэх хэсгүүдэд Оролцогч улс тусгайлан анхаарал хандуулахын зэрэгцээ дээрх хэсгүүдэд агуулагдах зөвлөмжүүдийг Оролцогч Улс хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тодорхой ямар арга хэмжээ авсан талаар нарийвчилсан мэдээлэл оруулж дараагийн ээлжит тайланд тусгахыг Хорооны зүгээс хүсч байна.

Дараагийн ээлжит тайланг бэлтгэх

39. Хорооны зүгээс 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Оролцогч улс өөрийн 25–27 дугаар ээлжит тайланг нэг бичиг баримт болгон нэгтгэж боловсруулах, ийнхүү тайлан бэлтгэхдээ тус Хорооны 71 дүгээр чуулганаас баталсан (CERD/C/2007/1) удирдамжийг баримтлах, тус дүгнэлт зөвлөмжид дэвшүүлсэн бүх асуудалд хариу бэлтгэн ирүүлэхийг зөвлөж байна. Ерөнхий Ассамблейн 68/268 тоот тогтоолд заасны дагуу нэгтгэсэн ээлжит тайланг 21,200 хэтрэхгүй үгэнд багтаахыг Оролцогч улс анхаарахыг Хорооны зүгээс анхааруулж байна.